

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-9

<i>1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	4-5
<i>2.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	5-9

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
04 дүгээр сарын 11-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 48 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Ц.Анандбазар, Ж.Батсуурь, Б.Жавхлан;
Чөлөөтэй: Ц.Даваасүрэн, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн.*

Нэг.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн газрын ахлах мэргэжилтэн Б.Уранчимэг, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн хуулийг төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд тараасан байгааг мэдэгдэв.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн газрын ахлах мэргэжилтэн Б.Уранчимэг, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Төсвийн байнгын хорооноос боловсруулсан тогтоолын төслийг Байнгын хорооны гишүүдэд тараасан байгааг мэдэгдэв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр батлуулах гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 20 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.5 хувийн ирцтэйгээр 15 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр,
Мягмар гараг

Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим 14 цаг 48 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая. Та бүхэнд юуны өмнө Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Ганибалын Амартүвшин,
Хавдисламын Баделхан, Жигжидийн
Батжаргал, Хүрэлбаатарын Булгантуяа,
Сайнхүүгийн Ганбаатар, Лхагвын
Мөнхбаатар, Салдангийн Одонтуяа,
Бөхчулууны Пүрэвдорж, Шатарбалын
Раднаасэд, Цэндийн Сандаг-Очир,
Дуламдоржийн Тогтохсүрэн нар хүрэлцэн
ирснээр нийт өнөөдрийн Байнгын
хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд 2023 оны 4 дүгээр сарын
11-ний өдрийн хуралдаан нээснийг
мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар
хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Засгийн газрын
тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт
оруулах тухай хуулийн төсөл, эцсийн
хэлэлцүүлэг.

Хоёрдугаарт, Хууль баталсантай
холбогдуулан авах арга хэмжээний тухай
Улсын Их Хурлын тогтоолын төсөл.
Төсвийн байнгын хороо санаачилсан
анхны хэлэлцүүлэг гэсэн ийм 2 асуудалтай
байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж
саналтай, асуулттай гишүүд байна
уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Засгийн газрын тусгай
сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах
тухай хуулийн төслийн эцсийн
хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлъе.**

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та
бүхэнд танилцуулъя. Цэндгомбын
Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн яамны Бодлого,
төлөвлөлтийн газрын дарга,
Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ Хөдөө аж
ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар
тариалангийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга, Энхбаатарын
Цолмонжаргал Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн
хэлтсийн дарга, Батжаргалын
Цогтсаран Хөдөө аж ахуйг дэмжих
сангийн гүйцэтгэх захирал,
Базаррагчаагийн Уранчимэг Хүнс, хөдөө
аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны
бодлого төлөвлөлтийн газрын ахлах
мэргэжилтэн гэсэн ийм
бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна.

Нэгдсэн хуралдааны анхны
хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан
саналыг хуулийн төсөлд нэмж тусган
эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл
болоод хуулийн төслийг эцсийн
хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай
танилцуулгыг та бүхэнд бэлтгэн
тараасан байгаа.

Эцсийн хэлэлцүүлэгтэй
холбогдуулаад асуулт асуух гишүүд байна
уу? Алга байна.

Хуулийн төслийг эцсийн
хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын
хорооноос гарах танилцуулгыг Улсын Их
Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулах
шаардлагатай байгаа.

Улсын Их Хурлын гишүүн
Ганбаатар гишүүн та чуулганд
танилцуулчих уу? За тэгье, Ганбаатар
гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа орцгооё.

14.50 цаг

Хоёр.Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаасантай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д заасныг үндэслэсэн Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооноос санаачлан боловсруулсан.

Ингээд та бүхэн Төсвийн байнгын хорооноос боловсруулсан тогтоолын төслийг тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу?Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Хөдөө аж ахуйг дэмжих санг татан буулгаж, хөдөө аж ахуйн корпорацит төрийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож түүнд шилжүүлж байна.

Энэ Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолын 2 дахь заалт. Хөдөө аж ахуйг дэмжих сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хугацаа хэтэрсэн өр, авлагыг ангилж, улсын төсөвт төлөх өр төлбөрийг 24 онд багтаан төлж барагдуулах үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, 24 онд багтаан төлж чадах юм уу? Одоогоор өр, авлага нь ямар

байгаа юм, хэд байгаа юм? Хэтэрсэн нь хэд байгаа юм? Авлагаар бүртгэлтэй нь хэд байгаа юм. Хэчнээн аж ахуй нэгж иргэнээс байгаа юм? Тэгээд 24 ондоо багтааж төлөх юм уу, хуваарь нь ямар байгаа юм? Гэрээ байгуулаад 24, 25 онд ингээд гэрээ байгуулчихсан бол яах юм өрөө барагдуулна гээд.

Тэгэхээр 24 ондоо төлж барагдахаар байгаа юм уу, барагдахгүй бол яах юм гэдэг асуудлыг та бүхэн юу гэж үзэж байгаа юм? Энэ тогтоолын хэрэгжилтийн 2 дахь заалт яг хэрэгжинэ гэж ойлгож байна уу? Энэ өр төлбөр чинь яг 24 ондоо бүрэн гүйцэд барагдаж чадах юм уу? Энэ дээр 1 тодорхой хариулт өгөөч.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Болорчулуун дарга хэдэн номер вэ?

Ц.Болорчулуун: Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ер нь бол сан дээр байгаа өр, авлагуудыг бид ерөнхийд нь ангилаад бэлдчихсэн, шүүхийн шийдвэр дээр 1 хэсэг нь явж байгаа. Тэгээд Монголбанкны мэдээллийн санд ерөнхийдөө өр, авлагатай аж ахуй нэгж иргэдийн мэдээлэл орчихсон. Сая бас энэ Цахим хөгжлийн яамнаас энэ шилэн данс дээр 5300 гаруй аж ахуй нэгж иргэдийн мэдээлэл орчихсон байгаа.

Тэгээд сан нь бол нийтдээ 10300 орчим харилцагчидтай байгаа юм. Үүнээс бол 2008 онд орж ирсэн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн Bavarian трактор 20, 25 мянга морины хүчтэй тракторыг нийтдээ 8400 трактор орж ирсэн. Энийг бол ер нь малчдад гэрээ байгуулж олгосон ийм асуудал байгаа.

Тэгэхдээ тухайн үед бол 5 сая төгрөгийн үнэлгээтэй байсан тракторыг 50 хувийн үнэлгээгээр нь 50 хувийг нь төлөвлөөд олгочихсон. Тэгэхээр малчид

дээр энэ 10300 гаруй харилцагчдаас 5000 гаруй нь бол малчид байгаад байгаа юм. Энэ бол мэдээллийн санд орчихсон учраас бас энэ сангийн харилцагчдын тоо нэлээд харагдаад байгаа. Энд бол мэдээж 500-аас 1 сая төгрөгийн өртэй ийм малчдын мэдээлэл нь түлхүү орчихсон байгаа.

Яг санд өртэй аж ахуйн нэгжүүдийг бол нийтдээ хоёр зуун авран ес, арван есөн тэрбум төгрөгийн өрийн асуудал байгаа. Үүнээс бол хугацаа хэтэрсэн нь 18 тэрбум төгрөгийн асуудал байгаа. Энэ нь бол 10-аас дээш жилийн насжилттай гэж байгаа. Бусдыг нь бол ингээд ангилаад, шүүхийн шийдвэр дээр 1 хэсэг нь байгаа. Тийм учраас бид нар бол ямар ч байсан Улсын Их Хурлаас өгч байгаа энэ чиглэлийн дагуу тодорхой хэмжээнд барагдуулахаар л ажиллана 24 ондоо.

Тэгэхдээ энэ сангийн өр, авлага бол бүхэлдээ энэ шинээр үйл ажиллагаа явуулах компани руу шилжих учраас бид нар ямар ч байсан төсөвт төлөх өрийг бол 24 ондоо барагдуулна гэсэн ийм тооцоотой л ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн нэмж тодруулах уу? Нэмж тодруулъя. Сандаг-Очир гишүүд микрофоныг.

Ц.Сандаг-Очир: Тийм, 10 орчим жил болчихож байна уу? Баахан ногоон тракторууд тараасан тэрийг хэлээд байна тээ? Тэгээд 24 ондоо гээд. Заавал энэ 24 онд багтаж гэж ингэж оруулах шаардлагатай юу? Харин би энэ ондоо багтахгүй бол яах юм бэ гэдэг асуудлыг л яриад байна шүү дээ. 5300 иргэдийн асуудал үүсэж байна. Тэгээд шүүхийн шийдвэр дээрээ очсон гэж байгаа юм байна. Цаашидаа энэ иргэн, аж ахуйн нэгжүүдийг, энэ Боловсролын зээлийн сан гээд л ингээд л бас эргэн төлөөгүй нөхдүүдийг гээд нэр усаар нь гаргаад байх юм. Хөдөө аж ахуйг дэмжих сангаас энэ зээл авсан аж ахуй нэгж, иргэдийн нэр ус тодорхой олон нийтэд ил тод болгох бололцоотой юу? Ингэж ер нь болгосон

уу? Ер нь 10-аад жил болчихсон гэж байх юм. Тэгээд энэ чинь төр биз дээ тэгээд? Ингээд яагаад 10-аад жил ингээд төрөөс, дэмжих сангаас ингээд зээл авчхаад, ингээд 1 ч төгрөг төлөхгүй ингээд яваад байдаг, болоод байдаг. Тэгээд та нар хаанаас нь яаж хөөц.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя, Болорчулуун.

Ц.Болорчулуун: Тэгэхээр сая энэ шилэн данс дээр бол нийтдээ 6092 аж ахуй нэгж, иргэний нэрийг shilen.gov.mn гээд энэ сайтууд бол бүгдээрээ байршсан байгаа. Монголбанканд бол энэ мэдээллүүд бас оччихсон байгаа. Тэгэхээр энэ дээр аж ахуй нэгж иргэдийн мэдээллийг ил тод байршуулж байгаа учраас энд бол нууж хаах асуудал байхгүй. Байнгын хорооны энэ хуралдааны үеэр бол бас гишүүдээс гарсан саналын дагуу хугацаатай үүрэг өгье тэгж энийг нэлээн шахаж төлөвлөг гэдэг байдлаар энэ 24 он гэдэг хугацаа гарч ирж байгаа.

Тийм учраас энэ хугацаанд нь ямар ч байсан нэлээн нарийвчилж ажиллаад төлөвлөг гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа.

Урьд нь бол мэдээж энэ үйл ажиллагаа явуулж байсан энэ хугацаанд бол бид өр төлбөртэйгөө төлүүлэх тал дээр бол олон талын арга хэмжээг авч хэрэгжүүлж ажилласан, ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулах уу Сандаг-Очир гишүүн? Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: 10-аад жилийн хугацаанд ямар арга хэмжээ авсан юм бэ? Яамны зүгээс энэ хугацаа хэтэрсэн өр, зээлийн асуудлыг хэрэгжүүлэх үүднээс? Ингээд 10-аад жилийн хугацаанд алдагдсан боломж, мөнгөн дүнгээр илэрхийлбэл хэд байх ёстой вэ? Энэ зээлийн эргэн төлөлт буцаад ахиад 1 иргэнд зээл болж очих ёстой биз дээ?

Ингээж эргэн төлөгдөх байдлаар дараа дараагийн зээл олголтын эх үүсвэр болж явах ёстой биз дээ? Энийг одоо бодож тооцоолсон юм Хөдөө аж ахуйн яаманд байдаг юм уу?

Ер нь өнгөрсөн хугацаанд дэмжих сантай холбоотой идэж уусан, шамшигдуулсан юм гарсан уу? Гарсан бол ямар хариуцлагын арга хэмжээ авсан бэ? Энэ талаар бас мэдээлэл авахыг хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Болорчулуун дарга асуултад хариулъя.

Ц.Болорчулуун: Өр, авлага барагдуулах тал дээр бас сангийн бүтцэд өр барагдуулах алба гэж байгуулаад, ажиллаад энэ өр, авлагыг бол ангилаад, ингээд шүүх рүү нэг хэсгийг нь өгөөд, ер нь шүүхийн шийдвэр гарчихсан 862 иргэн, аж гүй нэгж байгаа тухайлбал. Гэх мэтчилэн бол арга, хэмжээнүүдийг бас үе шаттайгаар авч ирсэн. Ингээд энэ бол 2019 оны Төсвийн тухай хуулиар Мал хамгаалах сан, хуучин Тариалан эрхлэлт дэмжих сан хоёр нэгдэж энэ Хөдөө аж ахуйг дэмжих сан болсон байгаа юм. Тэгээд энэ Мал хамгаалах сангийн дансанд байсан өр, авлага бол бас энэ ийшээ нэгдсэн.

Тэгэхээр хоёр сангийн үйл ажиллагаа нэгдсэнтэй холбоотойгоор энэ өр, авлага бас нэмэгдэж харагдаж байгаа. Тэгэхдээ бид нар бол энэ дээр хөрөнгө мөнгө шамшигдуулаад янз бүрийн хариуцлага тооцсон асуудал бол байхгүй. Өр, авлагаа бараг.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Нэмээд хариултаа гүйцээ. Болорчулуун дарга.

Ц.Болорчулуун: Тэгээд одоо бол бид нар зөвхөн компани болгоод шилжүүлээд өр, авлагаа барагдуулна гэж тооцоолохгүй. Одоо ч гэсэн шүүхийн шийдвэр дээр шүүхэд өгөхийг нь өгөөд, шийдвэр гүйцэтгэл дээр ажиллахыг нь ажиллаад ингээд л энэ өр барагдуулах

талдаа бол нэлээд анхаарч л ажиллаж байгаа. Тодорхой хэмжээгээр ч бас барагдаж байгаа. Тухайлах юм бол Монголбанкны мэдээллийн санд сүүлийн 2 жил оруулаад бас өр, авлага барагдах барагдалт бол нэлээд нэмэгдсэн байх жишээтэй.

Тэгэхээр газар тариалангийн үйлдвэрлэл өөрөө бас эрсдэлтэй. Тэгээд тухайн жил ургац алдахаар аж ахуй нэгжүүдийн төлөхөөр хойшилох гээд ийм нөхцөл байдал байгаа учраас энэ хуримтлагдсан өрнүүд нэлээн харагдаад байгаа юм.

Г.Тэмүүлэн: Тогтоолын төсөлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх үү Ганбаатар гишүүн. Ганбаатар гишүүн. Үг хэлэх өөр гишүүд байна уу? Алга байна. Ганбаатар гишүүнээр тасалъя. Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Энэ батлагдсан талтай холбогдуулж авах арга хэмжээний тухай хөдөө аж ахуйн корпорацыг ингээд хязгаарлагдмал хариуцлагатай төрийн өмчит компанийн засаглалыг ингээд байгуулж байгаа юм байна. Энийг дэмжиж байгаа 1 шалтгаан нь Хөдөө аж ахуйг дэмжих сан бол зөндөө сайн зүйл хийсэн байх. Тэгэхдээ асар доголдолтой, асар олон хэл ам дагуулсан ажлууд байгаа. Тэр зээл, хууль, танил тал, арай хүчтэй, нөлөөтэй хүн авдаг гэдэг яриа ер нь бол салахгүй байсан.

Тэгэхээр бид Хөдөө аж ахуйн корпорацыг дэмжиж байгаа шалтгаан нь урьд нь явж байсан энэ арга бас л хөлөө олохгүй байна гэдгээрээ дэмжиж байгаа. Энэ нь Хөдөө аж ахуйн корпорац өөрөө хүлээн авна гэсэн үг биш шүү. Бид өөр арга алга энийг дэмжинэ. Тэгэхээр хөдөө аж ахуйн корпорац дээр анхаарч ажиллаасай гэсэн 2 зүйлийг л би хэлэх гэсэн юм.

Нэгдүгээрт нийт ард түмний эрх ашгийг төлөөлөөд Улсын Их Хурлаас байгуулагдсан, томилогдсон, итгэлийг нь

авсан Засгийн газар тэр дотроо Хөдөө аж ахуйн яам хариуцаж байгаагийн хувьд энэ дээр тариалалт болон мал аж ахуйн тал дээр ямар ямар үр дүн гаргах вэ, яаж яаж ажиллах вэ гэдэг тал дээрээ үр дүнг тодорхойлох хамтын гэрээ хэлэлцээр авал байгуулах ёстой шүү. Энийг бол би асуулт асуусангүй. Заавал байгуулах ёстой. Энэ талаар тодорхой мэдээллээ Их Хурлын гишүүний шугамаар Болорчулуун дарга аа, яамдын хамт олон! Надад ямар драфт байгаа юм, ямар гэрээ байгуулах гэж байгаа юм? Одоо ингээд төрийн өмчит компани байгуулаад, хязгаарлагдмал хариуцлагатай комдани байгуулаад л, тэгээд л бүгдээрээ л идэж уудаг нэг том саалийн үнээ бэлдчихлээ гэдэг бодол руу орохгүйн тулд ямар үр дүн гаргах юм, яаж бидний өмнө хязгаарлагдмал хариуцлагатай гэж байгаа шүү дээ. Хариуцлагаа яаж үүрэх юм? Ямар үр дүн гаргах юм? Ямар хугацаанд, яаж? Энэ талаар яам болон холбогдох газрууд нь гэрээ байгуулсан байх ёстой. Гэрээний драфтыг үзье. Би асуулт асуусангүй. Та нарт бэлэн биш байвал тэр тухайгаа бэлдэж байгаа зүйлээ заавал хэлээрэй.

Хоёрдугаар миний асуулт. Хөдөө аж ахуйн корпорац нэгэнт ингээд байгуулж байгаа, тэр дотроо төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх хүрээнд гэж үг байгаа юм шүү. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх хүрээнд гэж байна. Дарга нарыг нь дандаа улс төрчид тавьдаг, тэгээд улс төрчдөд ээлтэй тийм хязгаарлагдмал хариуцлагатай төрийн өмчит компани бий болгохгүйн тулд яг олон жил энэ газар тариалангийн төлөө зүтгэсэн олон компаниуд байгаа. Яг энэ мал аж ахуй тэр дундаа эрчимжсэн мал аж ахуй, бэлчээр, тэжээлийн үйлдвэр гээд энэ олон Монголын стратегийн шүү дээ, гол асуудлууд дээр бас л бүх хөрөнгө, мөнгө, цаг нар, эрсдэлээ үүрээд явж байгаа энэ аж ахуйн нэгжүүд ямар зохион байгуулалттайгаар оролцож байгаа вэ гэдэг нь бидэнд сонин байна. Энэ талаараа, явцын талаар маш сайн бидэнд

мэдээлэл өгөөд, харин энэ дээр би санал хэлэх гээд байгаа юм нь Тэмүүлэн дарга аа та бол хөдөө аж ахуй тал дээр маш их анхаарал тавьж ажилладаг хүн. Малын эрүүл мэнд, мал аж ахуйн тал дээр тэгээд газар тариалан энэ дээр орж байгаа.

Тэгэхлээр энэ мал, аж ахуй эрхлэгчдийн болон мэргэжлийн холбоод, газар тариалан болон мал аж ахуй эрхлэгчдийн мэргэжлийн холбоодыг оролцуулж байж энэ засаглалыг бий болгоно гэж байгаа юм. Энэ явц дээр энэ төслийн хоёрдугаарт нь, тогтоолын хоёрдугаарт заасан байна л даа. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тэмүүлэн даргад даалгасан байна.

Тэгэхлээр энэ дээр та ажлын хэсэг байгуулах юм уу? Ямар нэгэн байдлаар энэ дээр яг энийг хэрэгжүүлэхэд бид нар тогтоол хэрэгжүүлээд л хаядаг. Нөгөөдүүл нь тэгээд л бөөн гомдол идлээ, уулаа, барилаа, тэгээд л нөгөө дарга талтай компаниудад зээл өгчихсөн байна гээд. Тийм биш байсан ч тийм гомдол гаргахгүйн тулд энэ хэрэгжилт дээр буюу засаглалыг нь төр, хувийн хэвшлийн түншлэлийг нь бий болгоход тариалан болон мал аж ахуй эрхлэгчдийн мэргэжлийн холбоодыг оролцуулах зохион байгуулалтын ажил дээр Байнгын хороо санаачилгатай оролцож, асуулга асууж үнэхээр энэ дээр улс төрчдийн тавиулууд биш, яг салбарт ажиллаж байгаа мэргэжлийн энэ зовлон зүдгүүрийг нь үүрээд явж байгаа хүмүүс энэ шийдвэр гаргах түвшинд, хяналтын хороонд нь оролчихсон юм байна гэдэг итгэлээ би авахын тулд энэ энэ тогтоолын 2 дугаар зүйл дээр манай Байнгын хороо идэвхтэй ажиллаж, Тэмүүлэн даргын мэдлийн асуудал зүгээр ажлын хэсэг байгуулах уу, шууд зүгээр өөрөө яваад шалгана уу энэ дээр онцгой анхаарах хэрэгтэй байна гэсэн ийм.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: Энэ тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой бас арга хэмжээг авах ёстой. Тэгэхээр ямар ч бай

хэрэв тогтоол батлагдсан тохиолдолд энэ хаврын чуулган дуусахаас өмнө Хөдөө аж ахуйн яамны зүгээс тогтоолын хэрэгжилттэй холбоотой биелэлт, явцын талаарх мэдээллийг Байнгын хороонд орж ирж танилцуулаарай гэсэн чиглэлийг бас энэ протоколоор өгч байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна. Тэгвэл санал хураалтыг явуулъя.

Тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжин 63.6 хувиар дэмжигдлээ.

Зарчмын зөрөөтэй санал гараагүй тул тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр батлуулах горимын саналыг бас гаргаж байна. Миний бие гаргаж байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.22-т заасны дагуу тогтоолын төслийн талаар зарчмын зөрөөтэй саналын томъёолол гараагүй тул тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр батлахыг дэмжье гэсэн саналаар санал хураалгах саналтай байна. Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад нийт 11 гишүүн оролцсон. 7 гишүүн дэмжиж, 63.6 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баделхан гишүүн та танилцуулах уу? Тэгье. Нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Хавдисламын Баделхан гишүүн танилцуулна.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ талархаж байна. Баярлалаа.

15.08 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

